



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 27 өдөр

Дугаар A/131

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээнд  
хамтран эзэмшигч нэмэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны өрөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Баавгай овогтой Баасанжав (РЭ80071806)-ын хүсэлтийн дагуу Мөрөн сумын 8 дугаар баг 13 дугаар байр, 27 тоот өргөтгөл ("Од" салон)-д байршилтай худалдаа, нийтийн үйлчилгээний зориулалттай 26м<sup>2</sup> газрын газар эзэмших эрхийн гэрчилгээнд иргэн Хишигсайханы Бямбасүрэн (РЭ78043018)-г хамтран эзэмшигчээр нэмсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан Б.Баасанжав, Х.Бямбасүрэн нартай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзүл) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

